

Агуулга

НЭГ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	2
Зорилго, үр дүн:.....	2
Хамарсан хүрээ:.....	2
Зохион байгуулалт, баг бүрэлдэхүүн:.....	3
Хугацаа:.....	3
Мониторинг хийж, зөвлөн тусалсан ажлын чиглэл:.....	3
ХОЁР: ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖИЛ	4
2.1 Хичээл ажиглаж, хэлэлцүүлэг хийсэн тухай.....	4
2.1.1 Хичээл ажигласан байдал: (ололттой ба сул тал).....	5
Бага боловсролын хувьд:.....	5
Байгалийн ухааны хичээлүүдийн хувьд:.....	6
Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр:.....	8
2.1.2 Хэлэлцүүлэг хийсэн байдал:.....	10
ГУРАВ: СУРГАЛТ БОЛОН ҮЗҮҮЛЭХ ХИЧЭЭЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ	12
Сургалтын онцлог.....	12
ДӨРӨВ: ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ (ҮР ДҮН, АНХААРАХ ЗҮЙЛ)	16
Дүгнэлт, үр дүн:.....	16
Анхаарах зүйлс:.....	17
<i>Боловсролын салбарын байгууллагуудын анхаарах зүйл: (оролцогчдын санал, хүсэлтэд үндэслэв.)</i>	17

“БАГШИЙН ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА-БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ” СУРГАЛТЫН ҮР ДҮНД МОНИТОРИНГ ХИЙХ, БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ЗӨВЛӨН ТУСЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН

НЭГ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Зорилго, үр дүн:

“Багшийн ёс зүй, харилцаа-бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зүй” сургалтын үр дүнд мониторинг хийж, үр дүнг тогтворжуулах, бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажлын байран дээр зөвлөн туслах, тэдэнд тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг илрүүлэн шаардлагатай дэмжлэгийг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлох зорилгоор тус үйл ажиллагааг 2017 оны 09 дүгээр сарын 25-аас 10 дугаар сарын 10-аас 19-ний хооронд зохион байгуулж дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

1. Орон нутагт зохион байгуулсан “Багшийн ёс зүй, харилцаа-бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зүй” сургалтын үр дүнд мониторинг хийж, дүгнэлт гаргасан.
2. Багшийн ёс зүй, харилцааны ур чадвар болон бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд үүсч буй асуудал, дэмжлэг үзүүлэх ажлын цаашдын чиглэл тодорхойлогдсон.
3. Багшийн ажлын байран дээр хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг хийж зөвлөгөө өгсөн нь багш алдаа, дутагдал, буруу ташаа ойлголтоо засаж залруулан хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх бодит дэмжлэг болсон.
4. Хөдөө орон нутгийн багш нарт сургалт, үзүүлэх хичээл зохион байгуулснаар тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх онол, арга зүйн мэдлэг, чадвар нэмэгдсэн.
5. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, орон нутгийн боловсролын байгууллага, сургууль, багшийн хамтын ажиллагаа дээшилж, харилцан бие биенээсээ суралцан, туршлага хуримлуулж зөвлөн туслах арга барилд тодорхой ахиц гарсан.

Хамарсан хүрээ:

Мониторинг хийж, зөвлөн туслах ажилд орон нутгийн 84, нийслэлийн 47, нийт 131 сургуулийг хамруулав. Аймаг тус бүрээс 4 сургууль, нийслэлийн хүн амын төвлөрөл ихтэй, олон сургуультай томоохон дүүрэг (Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар)-ээс тус бүр 8 сургууль, бусад дүүргээс тус бүр 4 сургуулийг хамруулсан. Сургуулийн сонголтыг аймаг, нийслэлийн БСУГ-тай зөвшилцөн дараах байдлаар хийв. Үүнд:

- аймгийн төвийн 3, сумын 1 (аймгийн төвийн сургууль нь төвд ба захад байршилтай)
- дүүргийн сургуулиуд нь төвд болон захад байршилтай
- лаборатори болон ердийн сургууль байхаар түүвэрлэлт хийсэн.

Хамрагдсан сургуулийн байршил, тоо зэргийг хүснэгтээр үзүүлбэл:

Бүс/ Сургууль	Лаборатори	Хот, аймгийн төвд байршилтай	Хот, аймгийн төвийн захад байршилтай	Сум ба алслагдсан дүүрэг	Нийт
Нийслэл	11	13	13	10	47
Орон нутаг	21	21	21	21	84
Нийт	32	34	34	31	131

Хамрагдсан сургуулийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1-д үзүүлэв.

Зохион байгуулалт, баг бүрэлдэхүүн:

2 аймаг, 1 дүүргийг нэг бүсэд хуваарилан нийт 11 бүсээр зохион байгуулав. Бүс тус бүрд БМДИ-ээс томилсон 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан ба нийт 11 бүсэд 33 хүн зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Тус багийн бүрэлдэхүүнд:

- БМДИ-22,
- БХ-2,
- МУБИС-4,
- Маргад дээд сургууль-1,
- ЕБ сургуулийн сургалтын менежер-5,
- Бодит чадвар академи-1,
- Багшийн хөгжил имидж төв-1, гэсэн байгууллагуудтай хамтран ажилласан.

Мөн тус үйл ажиллагаанд тухайн аймгийн БСУГ, НБГ, дүүргийн БХ-ийн мэргэжилтнүүд хамтран ажилласан гэдгийг тэмдэглэж байна. Нийслэлийн бүсэд ажилласан 5 хүн орон нутгийн бүсэд ажиллагаагүй солигдсон байна.

Хугацаа:

Зөвлөн туслах үйл ажиллагааг дараах хугацаанд зохион байгуулсан. Үүнд:

- Нийслэлийн төвийн дүүргүүдэд 2017 оны 09 дүгээр сарын 25-аас 28-ны өдрүүдэд, нийт 4 өдөр
- Аймгуудад 2017 оны 10 дугаар сарын 10-аас 19-ний хооронд, нэг аймагт 4 өдөр тус тус ажилласан.

Мониторинг хийж, зөвлөн тусалсан ажлын чиглэл:

Мониторинг хийж, зөвлөн туслах ажил нь үндсэн 3 чиглэлийн хүрээнд хийгдсэн. Үүнд:

- Сургууль тус бүрд бага боловсрол, нийгмийн ухаан, байгалийн ухаан гэсэн 3 судлагдахууны чиглэлээр багш нарын хичээлд ажиглалт хийж, хэлэлцүүлэг өрнүүлэх, мэргэжил, арга зүйн чиглэлээр зөвлөн туслах
- Тухайн бүсэд томилогдсон багийн гишүүд өөрсдийн хариуцсан мэргэжлийн нийт багш нарт сургалт зохион байгуулах. Тус сургалтыг зөвхөн хөдөө орон нутгийн багш нарт зохион байгуулсан ба нийслэлийн багш нарт тус сургалтыг хийгээгүй болно.
- Орон нутагт зохион байгуулсан “Багшийн ёс зүй, харилцаа-бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зүй” сургалтын үр дүнд мониторинг хийх гэсэн 3 чиглэлээр ажилласан.


Энэхүү тайланд зөвхөн зөвлөн туслах ажил болон сургалт зохион байгуулсан талаарх мэдээлэл, дүгнэлтийг өгүүлсэн бөгөөд орон нутагт зохион байгуулагдсан “Багшийн ёс зүй, харилцаа болон Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сургалтын чанар, үр дүнгийн мониторингийн тайланг тусад нь боловсруулсан болно.

ХОЁР: ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖИЛ


2.1 Хичээл ажиглаж, хэлэлцүүлэг хийсэн тухай

Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд нийт 690 хичээлд сууж ажиглалт хийсэн ба тус үйл ажиллагаанд нийт 320 орчим багш оролцсон байна.

Эдгээрийг боловсролын түвшингээр нь авч үзвэл бага боловсролын 241, суурь боловсролын 223, бүрэн дунд боловсролын 226 хичээл байна.



Харин судлагдахууны чиглэлээр авч үзвэл:



Ажигласан хичээлийн тухай мэдээлэл:

№	Судлагдахуун	Бүс	Ажиглалт хийсэн хичээлийн тоо			Нийт
			Бага	Суурь	Бүрэн дунд	
1	Бага боловсрол	Нийслэл	81			241
		Орон нутаг	160			
2	Монгол хэл, бичиг, уранзохиол	Нийслэл		12	12	72
		Орон нутаг		24	24	
3	Түүх, нийгмийн ухаан	Нийслэл		8	8	32
		Орон нутаг		8	8	
4	Дүрслэх урлаг, дизайн технологи	Нийслэл		9	8	40
		Орон нутаг		11	12	
5	Биеийн тамир	Нийслэл		8	8	43
		Орон нутаг		12	15	
6	Гадаад хэл	Нийслэл		9	7	42
		Орон нутаг		15	11	

7	Физик	Нийслэл		8	6	30
		Орон нутаг		7	9	
8	Математик	Нийслэл		8	8	32
		Орон нутаг		8	8	
9	Хими	Нийслэл		5	4	25
		Орон нутаг		8	8	
10	Биологи	Нийслэл		8	6	44
		Орон нутаг		15	15	
11	Газарзүй	Нийслэл		6	10	46
		Орон нутаг		16	14	
12	Мэдээллийн технологи	Нийслэл		3	5	24
		Орон нутаг		8	8	
13	Хөгжим	Нийслэл		3	3	19
		Орон нутаг		4	9	
Нийт			241	223	226	690
			690			

Хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг нь дараах үе шат, зохион байгуулалтын дагуу хийгдэж, хүн бүр бүтээлч оролцоотой, хариуцлагатай байхыг чухалчилсан.

№	Үйл ажиллагаа	Зохион байгуулалт
1	Хичээлд сууж ажиглах	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн арга зүйч бүр тухайн сургуулийн бага, суурь, ахлах ангийн тус бүр хоёроос доошгүй хичээлд сууж, ажиглалт хийн, тэмдэглэл хөтөлсөн. Орон нутгийн мэргэжилтэн, тухайн сургуулийн мэргэжлийн багш нар, сургалтын менежерүүдтэй хамтран, хичээл ажиглалт хийсэн.
2	Хэлэлцүүлэг хийх	<ul style="list-style-type: none"> Хичээлийн явцад хүн бүр ажиглалтын хуудас бөглөн, хэлэлцүүлэгт бэлтгэсэн. Хэлэлцүүлгийг хичээл ажиглалтын хуудасны дагуу, дараах дарааллаар зохион байгуулсан. <ul style="list-style-type: none"> Хичээл заасан багш хичээлийн төлөвлөлт болон хичээлийн явцыг танилцуулах. Мэргэжлийн багш нар, сургалтын менежер, орон нутгийн тухайн судлагдахуун хариуцсан мэргэжилтэн, арга зүйчид ажиглалтын хуудасны дагуу хичээл сайжруулах саналаа хэлэх Хичээл заасан багш хэлэлцүүлгийн саналыг нэгтгэн, тэмдэглэл хөтлөх.
3	Зөвлөмж өгөх	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн мэргэжилтэн, мэргэжлийн арга зүйчид жилийн болон нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлттэй танилцан, хичээлийн ажиглалт тэмдэглэлд үндэслэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж өгнө.

2.1.1 Хичээл ажигласан байдал: (ололттой ба сул тал)

Хичээлд сууж, ажиглалт хийсэн багийн гишүүдийн тэмдэглэл, тайлангаас харахад бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой дараах ололттой бол анхаарах шаардлагатай зүйлүүд байна. Үүнд:

Бага боловсролын хувьд:

Бага боловсролын 241 хичээлд сууж, ажиглалт хийсэн тэмдэглэлээс нийтлэг ололттой ба сайжруулах шаардлагатай талыг шүүж үзвэл:

- ✓ Ихэнх багш нарын хувьд хичээлийн хэрэглэгдэхүүн, тарааж өгөх материалыг өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан бэлтгэж, хичээлдээ бүтээлчээр

хэрэглэхийг хичээсэн. Сурагчдыг хичээлдээ идэвхтэй оролцуулан, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, ярих чадварыг хөгжүүлж байна. Мөн зарим багш нарын тухайд хичээлийн зорилго, зорилтоо “SMART” байдлаар тодорхойлж, хичээлээ үр дүнтэй зохион байгуулсан бөгөөд олонх сургууль, багш нарын хувьд цахим хичээлийн сантай, түүнийгээ ТВ ашиглан сурагчдад үзүүлж байгаа давуу тал байна.

Харин дийлэнх багш нарын хувьд сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжаа судлаагүй уялдаа холбоог нь ойлгоогүй, хичээлийн төлөвлөлтийг оновчтой боловсруулж, бэлтгэлийг сайтар хангаагүй, заах зүйлээ судлаагүй зэрэг нийтлэг дутагдал байгаа талаар тэмдэглэсэн байна. Тухайлбал: Математикийн хичээлийн хувьд сурах бичиг дээрх тоог жиших, нэрлэх, нэгээр нэмэх үйлдлүүд нь ямар зорилготойг багш өөрөө сайн ойлгох, монгол хэлний хувьд бичих үйлийг унших үйлтэй холбох, хичээлийн агуулгыг сайн судлах зэрэгт анхаарах хэрэгтэй. Мөн самбар төлөвлөлт, бичиглэлд нийт багш нар анхаарч цэгцтэй, ойлгомжтой байх, хүүхдэд бодох хугацаа өгөх, сурагчдын унших, сонсох чадварыг хөгжүүлэхэд бүтээлч хандах, алдааг хянах, засах зэргээр багш мэдрэмжтэй хандах шаардлага ч байна. Түүнчлэн сурах бичиг барьсаар байгаад хичээл дуусгаж байгаа багш нар их байгаа ба хэрэглэгдэхүүний хүртээмж, сонголт, аюулгүй байдлыг тооцоогүй зэрэг сул талууд байна.

Байгалийн ухааны хичээлүүдийн хувьд:

- ✓ Математикийн нийт 32 хичээлд сууж, ажиглалт хийсэн байна. Математикийн судлагдахууны хувьд багш нар явцын үнэлгээний түгээмэл аргуудыг хүүхдийг идэвхжүүлэх зорилгоор хэрэглэж байгаа ба үндсэн сургалтад хамрагдсан залуу багш нар нь хүүхдийн сонирхлыг татах зорилгоор шинэлэг арга хэрэглэхийг оролдох, санаа гаргахад бүтээлчээр ханддаг болсон байна. Мөн цөөн тооны багш хичээл төлөвлөлтөө оновчтой боловсруулж, сурагчдын оролцоог хангасан арга зүйгээр хичээлээ зохион байгуулж байгаа бөгөөд математик хэллэг, нэр томъёог зөв хэрэглэж сурахад анхаарч, сурагчдын гаргаж буй алдааг тухай бүрд нь засаж байгаа нь зэрэг ололттой тал ажиглагдлаа. Харин дийлэнх багш нарын хувьд хичээлийн бэлтгэл хангалтгүй байдал нийтлэг байгаа бөгөөд энэ нь сургалтын менежер төлөвлөлт батлах төдийгөөр хяналт тавьдагтай нэлээд холбоотой. Мөн мэдлэг бүтээлгэхэд чиглэсэн чухал алхмыг алгасах, шууд хэлж өгөх зэргээр багшийн хэт оролцоо болон цагтаа багтаахад яарсан байдал нь цаашид заах хичээлүүдийн үр нөлөөг бууруулж, магадгүй “шинэ хичээл заасаар байгаад хичээлийн жил дуусдаг” гэсэн гомдлын шалтгаан нь болох магадлалтай байна. Сурах бичгийн хүрэлцээгүй байдал нь багш, сурагчдад хүндрэл үүсгэж байгаа ба хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгийг ойлгож хэрэглэж чадахгүй байгаа тохиолдлууд ч цөөнгүй байна. Тиймээс цаашид сургуулийн удирдлагын зүгээс хичээл ажиглаж зөвлөн туслах, төлөвлөлтийг сайжруулахад нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахад шаардлагатай талаар тайланд тусгагджээ.
- ✓ Газарзүйн судлагдахууны хувьд нийт 46 хичээлд сууж, ажиглалт хийсэн байна. Тус хичээлийн эхэнд зорилго, зорилтыг дэвтэрт тэмдэглүүлж, хичээлийн төгсгөлд дүгнэж байсан нь багш өөрийн үйл ажиллагаандаа үнэлгээ, дүгнэлт хийх боломжийг бүрдүүлж байв. Мөн газарзүйн зураг, видео, ажлын хуудсыг ашиглаж байсан нь сурагчдад сонирхолтой байхаас гадна хичээлийг илүү бодитой, үр дүнтэй явуулахад нөлөөлж байгаа сайн тал байна. Харин хичээлийн төлөвлөлт хийхдээ суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжид тулгуурлах, нэгж, ээлжит хичээлийн зорилго, зорилтыг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж, хичээлийн үнэлгээ хийх, сурагч өөрийгөө үнэлэх дасгал, даалгаврыг сайтар төлөвлөх, сурагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт тохируулж өмнө судалсан

агуулгатай холбоотой асуултыг урьдчилан бэлтгэх зэрэгт анхаарч сайжруулах шаардлагатай гэж мэргэжлийн арга зүйч дүгнэжээ.

- ✓ Физикийн хувьд нийт 30 хичээлд сууж, ажиглалт хийсэн. Физикийн хичээлийн тухайд суурь, бүрэн дунд боловсролын хэрэгжилт харилцан адилгүй байна. Хэнтий аймагт физикийн багш нар нэлээд хамтарч ажилладаг бол Багануур дүүрэгт багш нарын хамтын ажиллагаа хангалтгүй байна. Мөн тооцоот бодлого бодуулж байгаа нь сайн талтай боловч бодлого бодох олон аргуудыг ашиглах шаардлага байна. Сургууль бүр ямар нэгэн туршилтын багажтай байгаа боловч түүнийг зөв зохистой, үр дүнтэй хэрэглэх байдал дутмаг байна. Нийт багш нарын хувьд хичээлийн төлөвлөлт, бэлтгэлийг сайжруулахад анхаарах шаардлагатай бөгөөд ялангуяа туршилттай хичээл орохдоо туршилтын багажаа зөв сонгох, аюулгүй байдал, бүрэн бүтэн ажиллагааг шалгах, асуултаа зөв оновчтой төлөвлөх, сурагчдад бодож хариулах хугацаа олгох зэрэгт нийт багш нар анхаарах шаардлагатай. Ахмад, туршлагатай зарим багш нарын хувьд багш өөрийн арга барилаа өөрчлөх дургүй байх хандлага ажиглагдсан ба хэдийгээр хичээл нь онолын алдаагүй боловч ахлах ангид хэрэгжүүлж байгаа арга зүйгээр хичээлээ заагдахгүй байгаа нь физикийн хичээлийг сонгон судлах сурагчдын хэрэгцээ, сонирхолд нөлөөлөх магадлал байна. Багш нар хичээлээ голчлон сурах бичгээс зааж байна. Иймд цөм хөтөлбөр, багшийн ном, арга зүйн зөвлөмж, сурах бичгийг хооронд нь уялдуулж судлан хичээл төлөвлөлт, хөтөлбөрөө сайжруулах, арга зүйгээ өөрчлөх, агуулгын залгамж холбоог судлах зэрэгт хэрэгтэй.
- ✓ Химийн судлагдахууны хувьд 25 хичээлд сууж ажиглалт хийсэн. Бусад судлагдахуунтай харьцуулахад харьцангуй цөөн¹ болно. Химийн хичээлийн тухайд суурь боловсролын агуулга боломжийн явагдаж байна. Харин Бүрэн дунд боловсролын агуулга өөрчлөгдөж байгаатай холбогдуулан зарим сэдвийн агуулгыг суралцахуйн удирдамжаа харалгүй үндэсний хөтөлбөрийн агуулгаар орж байгаа нийтлэг зөрчил ажиглагдсан. Багш нарын хувьд өмнөх хичээлийн залгамж холбоог гаргаж тухайн хичээлтэй холбож заах тал дээр анхаарах шаардлагатай. Жилийн болон нэгжийн төлөвлөлтийг дахин сайжруулах буюу тухайн сэдвийн агуулга хүнд, хөнгөнөөс хамаарч цагийн хуваарилалтыг дахин хийхгүй бол нэгэн жигд цаг тавьсан байх жишээтэй. Төв аймгийн хувьд сургуулиуд кабинетын зарчмаар хичээллэхгүйгээс химийн хичээл бүр дээр туршилтаар мэдлэг бүтээлгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа зүйл ажиглагдаж байна. Багш нар хичээл дээр ажлын хуудас ашиглаж байгаа боловч энэ нь сурагчдаар мэдлэг бүтээлгэх бус багш хичээлийг удирдан явуулахад чиглэсэн асуултын төлөвлөгөө байдлаар ашиглах тохиолдол дийлэнх байна. Химийн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодис урвалж дутмаг байгаагаас зарим агуулга бүрэн хэрэгжих боломж, нөхцөл бага байгаа нь ажиглагджээ.
- ✓ Биологийн судлагдахууны тухайд нийт 44 багшийн хичээлд сууж, ажиглалт хийсэн байна. Тайлангаас үзэхэд ололттой талыг төдийлөн тодорхой тэмдэглээгүй, харин анхаарах шаардлагатай зүйлсийг нэлээд тодорхой тусгажээ. Үүнд: Агуулгын залгамж холбоогоо судлаагүйгээс хүнддүүлэх болох хэт хөнгөдүүлэх тал түгээмэл, ээлжит хичээлийн төлөвлөлт багшийн үйл ажиллагаа голлосон, ихэвчлэн агуулга төвтэй байна. ШУАБ-р хичээлээ төлөвлөсөн боловч хичээлийн алхам үйл ажиллагаанууд нь зөрөөтэй, ШУАБ үе шатын дагуу хэрэгжихгүй саланги үйлүүд хийгдэж, үр дүн дүгнэлт хийгдэхгүй зэрэг алдаанууд тухай тэмдэглэсэн байна. Мөн ажлын хуудас нь мэдлэг бүтээлгэхээс илүү тарааж өгөх материалын шинжтэй

¹Учир нь химийн арга зүйч төрсний дараах амралттай тул зочин багшийг урьж Хөвсгөл, Төв аймаг, болон Чингэлтэй дүүрэгт ажиллуулсан.

байгаа ба багшийн асуулт тодорхойгүй, жилийн болон нэгжийн төлөвлөлт боловсруулахдаа суралцахуйн зорилт, үйл ажиллагаагаа судалж багцлаагүй, үнэлгээг төлөвлөөгүй ба үнэлгээний шалгуур нь агуулгад суурилсан зэрэг сул тал байгаа талаар дурджээ.

- ✓ Мэдээллийн технологийн 24 хичээлд сууж, ажиглалт хийсэн байна. Судлагдахуун хариуцсан мэргэжилтэн нийслэлийн 4 сургуульд ажилласан ба хүндэтгэх шалтгааны улмаас хөдөө орон нутагт ажиллаагүй тул Өмнөговь, Дундговь аймагт зочин багшийг урьж ажиллуулав. Дундговь аймгийн хувьд аймгийн хэмжээнд нэг нэгдсэн хөтөлбөрөөр явж байгаа нэртэй боловч анги бүрийн жилийн хөтөлбөрийн боловсруулалтын загвар өөр өөр, суралцахуйн зорилтоо нэг ангиас бусад ангид огт дурдаагүй, сэдэвт баримжаалсан хөтөлбөр хийсэн байсан. Харин I сургууль дээр заасан сэдэв III сургууль дээр сайжруулсан байдлаар заагдаж байгаа нь сайн талтай. Мөн зарим багш хичээлийг туршилттай явуулахаар бэлтгэсэн нь сайн байгаа боловч хэрэглэгдэхүүний хүртээмжид анхаарах шаардлагатай байна. Харин Өмнөговь аймгийн хувьд нийтлэг ажиглагдсан сул талд багш бүр суралцахуйн зорилтоо өмнөө тавьж хичээлээ төлөвлөх, зорилтод хүрэхийн тулд хүүхдээр яг юу хийлгэх вэ? гэдгээ сайтар тунгаан, түүнийгээ багш туршин үзэх, ямар бэрхшээл гарч болохыг тооцоолох, хэрэглэгдэхүүний хүртээмжтэй байдлыг бодолцох, сурагчдад ямар арга барилтай болгоход энэ хичээл хувь нэмэр болохыг тооцож байх зэрэгт анхаарах шаардлагатай талаар дурджээ. Мөн аймгийн төвийн 6 багш мэргэжлийн бусад сумдын багш мэргэжлийн бус багш нар мэдээллийн технологийг зааж байгаа нь энэ хичээлийн ач холбогдлыг бууруулж байгааг анхаарах хэрэгтэй юм. Тухайлбал: 1-р ангийн багш ангидаа хичээлээ заахаас гадна Мэдээллийн технологи хичээлийг заадаг. Нийслэлийн багш нарын тухайдээлжит хичээлийн бэлтгэл дунд зэрэг байгаа ба суралцахуйн зорилт, үйл ажиллагаатай нь төлөвлөсөн хичээл нь зөрөх тохиолдол ажиглагдсан, гэхдээ анги болон сурагчийн хүлээн авах чадвар, ялгаатай байдлыг багш гярхай ажиглаж тухай бүр өөрчлөн шийдвэрлэж байсан. Суралцахуйн удирдамжаа судалж тухайн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх суралцахуйн үйл ажиллагаандаа баримжаалан сурагчдын чадвар, хэрэглэгдэхүүний нөөцөө урд өмнө хэвлэгдэн гарсан сурах бичиг хэрэглэн бэлтгэж байна, өмнөх мэдлэг төсөөлөл, агуулгын багтаамжаа гүйцэтгэх үйл ажиллагаандаа баримжаалан жилийн төлөвлөлтөө дүүргийн багш хамтран боловсруулж, байнга сайжруулан хэрэглэдэг зэрэг давуу талтай байгааг тэмдэглэсэн.

Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр:

- ✓ Монгол хэл, бичиг, уранзохиолын 72 хичээлд сууж, ажиглалт хийсэн. Сургууль бүр цөм хөтөлбөрийн мөн чанараа ойлгож хэрэгжүүлэхийг хичээж байгаа боловч багш нарын арга зүй, дадлага туршлагаас шалтгаалан янз бүр байна. Шинээр төгсөж ирж буй багш нарын цөм хөтөлбөрийн талаарх мэдлэг ойлголт, багш нарын мэдлэг чадварын түвшин, удирдлагын арга барил, багш нарын хамтын ажиллагаа үүнд нөлөөлж байна. Сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, тэдний ярих, бичих, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн хичээлүүд явагдаж байгаа боловч хөтөлбөр, сурах бичгийн уялдаа холбоо, ямар суралцахуйн зорилтын хүрээнд яаж илэрснийг судалсны үндсэн дээр хичээлээ төлөвлөх, төлөвлөсөн хичээл дээрээ сурагчдын сурах арга барилыг хөгжүүлэх асуулт хэрэглэх, сурагчдын үйл ажиллагааг зөв чиглүүлэх, дэмжих арга зүй дутмаг байна. Мөн сурагчийн унших, бичих, ярих, сонсох чадварыг хэрхэн хөгжүүлэх талаар хичээлийн үйл ажиллагааны алхамд суугаагүй, хичээлийг мэдлэг талаас төлөвлөх явдал түгээмэл байна.

- ✓ Түүх, нийгмийн ухааны нийт 32 хичээлд сууж, ажиглалт хийсэн. Багшийн ур чадвар болон сурагчдын түүхэн үг хэллэг ашиглан ярих чадвар сайжирч байна. Сурах бичиг байхгүй байгаагаас багш нар өөрсдийн нөөц бололцоогоор ажлын хуудас, өмнөх оны сурах бичгийг хичээл сургалтаддаа ашиглаж байгаа нь ажиглагдсан. Суралцахуйн зорилтыг ээлжит хичээлийн зорилго болгон буулгахдаа бүхэллэг байдлаар шууд хуулбарласан, хичээлийн бэлтгэл хангалттай бус, хүснэгтэн мэдээллийг ажлын хуудас хэмээн ойлгож, хэрэглэж байгаа байдал ажиглагдлаа. Иймд ээлжит хичээлийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийн дагуу төлөвлөх, НУ-ны сонгоны болон 12 дугаар ангийн Монголын түүхийн хичээлийг суралцахуйн удирдамжийн дагуу хичээлийг төлөвлөж зохион байгуулах, нийгмийн ухааны сонгон судлах хөтөлбөр асуудал төвтэй агуулга байгааг анхааран заавал судлах хөтөлбөрөөс агуулгыг ялган төлөвлөх шаардлагатай байна. Сонгон судлах хөтөлбөрийн дагуу судалгааны бүтээл, сүүлийн үеийн шинжлэх ухааны ололт, зангилаа асуудлыг уншиж судлах онолын мэдлэгээ сэргээх хэрэгцээ, шаардлага багш нарт байна. Иймээс сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичиг, багшийн номыг цогцоор нь хэрэглэж хичээлээ төлөвлөх шаардлагатай байна.
- ✓ Дүрслэх урлаг, дизайн технологийн 40 хичээлд сууж, ажиглалт хийсэн. Нутгийн онцлогийг харуулсан сав баглаа боодлын дизайн гаргах, хичээлийг хүүхдээр оюуны довтолгоо хийлгэж ажиллуулж байгаа нь сайшаалтай боловч нутгийн бренд болох бүтээгдэхүүний төрөл ангиллыг тодорхойлон өрөлт хийж бүлэг биет болгон түүн дээрээ бүлэг биетийн проекц гарган сав баглааг шийдсэн бол илүү үр дүнтэй хичээл болох байсан гэж үзсэн байна. Мөн ихэнх багш дээр нийтлэг ажиглагдсан дутагдалтай тал бол сурах бичиг, хөтөлбөрт тусгасан ижил нэртэй агуулгыг түвшингийн ялгааг гарган зааж чадахгүй байгаагаас анги бүрд нэг зүйлээ давтан орж байгаа зүйл ажиглагдаж байна. Тухайлбал Үндэсний гар урлалын төрөл, орчин үеийн гар урлалын төрлийн ялгаа, онцлогийн талаар хичээлийг 12-р ангид орсон байна. Гэвч энэ хичээл нь сурах бичгийн 6, 7, 8-р ангид үздэг сэдвээс хүндэрсэн агуулга биш байсан гэж тэмдэглэсэн байна. Дизайн, зураг зүй, технологи судлагдахууны багш нарт цөм хөтөлбөр болон суралцахуйн удирдамжийг судлах, хичээлийн мэдлэг бүтээх шинэлэг арга зүй сайжруулах, хичээлийн төлөвлөлт, хичээлийн хэрэглэгдэхүүн сайжруулах, үнэлгээг анхаарах, хичээлийг технологийн дагуу явуулах тал дээр анхаарах нь зүйтэй байна. Мөн дизайн технологи хичээлийн суурийн хөтөлбөрийн агуулга заах багш нарын мэргэжлийг дээшлүүлээгүйгээс зурагзүй буюу технологийн аль нэгийг заахгүй өнгөрөх, ихэвчлэн технологи заасан байна гэж онцгойлон тайландаа тусгасан байна.. Жилийн ажлын төлөвлөлт, ахлах ангийн хөтөлбөр, суралцахуйн удирдамжаа барьж ажиллах талаар зөвлөгөө өглөө.
- ✓ Гадаад хэлний нийт 42 хичээлд сууж, ажиглалт хийсэн тэмдэглэлээс нийтлэг ололттой ба сайжруулах шаардлагатай талыг шүүж үзвэл: Ихэнх гадаад хэлний багш нарын хэл ярианы чадвар боломжийн байна. Суурь болон бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай тодорхой хэмжээгээр холбогдож байлаа. Гадаад хэлний хичээл дээр сонсох, ярих чадварыг түлхүү хөгжүүлэх талаар анхаарч ажиллаж байгаа нь харагдсан. Багш дэмжих асуултуудаар сурагчдыг чиглүүлж өгч байгаа нь сурагчдын ярих чадварыг хөгжүүлэхэд сайн дэмжлэг болж байгаа ололттой тал ажиглагдаж байлаа. Дараах зүйлүүд дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үүнд: Багш бүр “Lesson agenda” буюу үйл ажиллагааны алхамчлалаа самбар дээр бичих /байрлуулах/, түүний дагуу хичээл зорилго, зорилтдоо хэрхэн хүрч байгаад хяналт тавих, мөн хичээлийн дүгнэлт дээр “Lesson

agenda"-г ашиглах, шинэ үг, хэллэгүүд дээр тогтож ажиллах, өгүүлбэрийн бүтцийн загвар болон жишээ өгүүлбэр өгч ярих, бичих чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаандаа ашиглах хэрэгтэй. Аль ч хичээл дээр ангиар болон бие даасан үйл ажиллагаа зонхилж байгаа тул гадаад хэлний хичээл дээр багаар болон хосоор ажиллах үйл ажиллагааг голчлон сурагч багштайгаа төдийгүй сурагч сурагчтайгаа, багтайгаа, бусадтайгаа харилцаанд чөлөөтэй оролцох боломжийг бий болгох шаардлагатай байна. Сурагчид сонсоод ойлгож байгаа хэдий ч өөрийн үгээр илэрхийлэх, ярих чадвар тааруу тул энэ тал дээр багш нар түлхүү анхааран ажиллах шаардлагатай байна. Ээлжит хичээлийн үйл ажиллагаа бүр сурагчийн хэлний аль нэг чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой зорилготой байх ба үйл ажиллагаа, даалгаврууд хоорондоо харилцан уялдаа холбоотой байх бөгөөд 1 ээлжит буюу 40 минутын хичээл дээр олон биш дунджаар 3-4 үйл ажиллагаа төлөвлөн хэрэглэгдэхүүнийг оновчтой, хүртээмжтэй, дахин ашиглах боломжтойгоор сонгож ашиглаж байх, сурагчдыг ярьж байхад алдааг засахгүйгээр дараа нь хичээлийн дүгнэлт дээр сурагчдын алдаатай хэлсэн үг, өгүүлбэр дээр тогтож ажиллавал илүү үр дүнтэй гэж үзэж байна.

- ✓ Биеийн тамирын нийт 43 хичээлд сууж, ажиглалт хийсэн. Багш нар нь арга зүйн хувьд бие бялдраа хөгжүүлэх, эрүүл мэндээ хамгаалах арга барилд тулгуурлан хичээлийн төлөвлөлтийг хийж, хэрэгжүүлж байгаа нь сайн талтай байлаа. Мөн Дорнод аймгийн багш нар 2016 онд зохион байгуулагдсан “Сайн хичээл” үйл ажиллагаанд оролцож бие биенээсээ суралцан хамтран ажилладаг сайн туршлага байсан ба энэ туршлагыг үргэлжлүүлж байгаа байна. Багш нар суурь боловсролын хөтөлбөрийн агуулга болон спортын төрлүүдийн орох ангийг нарийн харж төлөвлөхгүй бол агуулгын залгамж холбоо алдагдах тал байгааг анхаарч сайжруулах хэрэгтэй байна.

2.1.2 Хэлэлцүүлэг хийсэн байдал:

Хичээлд ажиглалт хийсний дараа дээр дурдсан дараалал, зохион байгуулалтын дагуу хэлэлцүүлэг хийсэн байна. Хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 3500 орчим багш болон удирдах ажилтнууд оролцжээ.

Тус ажлыг хариуцан ажилласан багийн гишүүд хичээл ажиглалтын хуудасны дагуу хэлэлцүүлгийг удирдан явуулсан бөгөөд заасан хичээлийн зорилго, төлөвлөлт, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг хэрхэн сайжруулах талаар тодорхой зөвлөгөө өгөхөөс гадна тухайн судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах онцлог зүйлүүдийн талаар зөвлөсөн байна. Энд бүх судлагдахууны хувьд өгсөн зөвлөгөөг нийтлэг байдлаар нь авч үзвэл:

- Хичээлийн төлөвлөлтийг сайжруулах талаар:
 - Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгийн уялдаа холбоог хэрхэн ойлгож, ашиглах
 - Нэгж болон ээлжит хичээлийн зорилго зорилтыг хэрхэн оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх
 - Туршилттай хичээлийг зохион байгуулах арга, аргачлал, анхаарах зүйл
 - Агуулгын өргөсөл, гүнзгийрлийн ялгааг ойлгож, онолын мэдлэгээ ахиулах
 - Үнэлгээний шалгуур боловсруулах, шалгууртаа нийцсэн дасгал, даалгавар, ажлын хуудас боловсруулах, ажлын хуудас, дасгал даалгавар нь суралцах чадварын хөгжлийг илрүүлэхүйц, үнэлгээний нотлох баримт, арга хэрэгсэл болохуйц байх
 - Явцын үнэлгээнд гүйцэтгэлийн түвшин, чадварын ахицыг илрүүлэх рубрук боловсруулж хэрэглэх зэргийн талаар жишээ баримтаар тайлбарлажээ.

Хэлэлцүүлэгт оролцсон удирдах ажилтан болон багш нар, нийт хүмүүсээс дараах санал, хүсэлтийг тавьсан байгааг нэгтгэвэл:

- Зөвлөн туслах ажлыг мэргэжлийн байгууллагаас тогтмол хийж байх
- Зарим аймгуудад зарим мэргэжлийн арга зүйч байдаггүй давхар хариуцдаг тул сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд зөвлөгөө өгөх тал дээр дутмаг байна. Тиймээс мэргэжлийн арга зүйчтэй болгох эсвэл үндэсний сургагч багшийг багш нараас сонгон бэлтгэх
- Арваас дээш жил ажилласан багш нар хуучин арга барилаа бүрэн шинэчлээгүйгээс нэг хэвийн тогтсон аргаар хичээлийг явуулж байгааг анхаарч арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, багшийн ном, сурах бичгийн уялдаа холбоог маш сайн судлах ажлыг заах аргын нэгдлийн ажлаар тогтмолжуулах
- Аль ч хичээл дээр ангиар болон бие даасан үйл ажиллагаа зонхилж байгаа тул гадаад хэлний хичээл дээр багаар болон хосоор ажиллах үйл ажиллагааг голчлон сурагч багштайгаа төдийгүй сурагч сурагчтайгаа, бусадтайгаа чөлөөтэй оролцох боломжийг бий болгож сурагчдын гадаад хэл сурах сонирхол, идэвх, оролцоог нэмэгдүүлэх
- Хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг сургалтын менежерт үзүүлээд хавтсанд хийгээд хадгалах, нэг багш нь боловсруулаад бусдад өгөх гэх мэт аргыг халж хүүхдэд зориулан сэтгэлээсээ боловсруулдаг байх
- ЗАН-ийн ажлыг тодорхой чадварыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг яаж төлөвлөх, сурах бичгийг яаж хэрэглэгдэхүүн болгон бүтээлч ашиглах арга зүйг судлах, үнэлгээний арга зүйд сурах зэрэг асуудлаар сургууль хичээлийн судалгааг сайн хийж байх хэрэгтэй. Энэ талаар сургалтын менежерүүдийг маш сайн сургах шаардлага байна.
- ЕБС-ийн түвшинд хэрэгжүүлж буй эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгож хурдан шийдэх
- Төрөл бүрийн нэрэмжит олимпиад уралдаанд мөнгөөр орох, ном зарах асуудлыг зохицуулах эрх зүйн баримт бичигтэй болох /IQ, кенгуру, математик сонин, стандарт олимпиад гэх мэт/
- БХ, БМДИ, БҮТ-ийн хоорондын үйл ажиллагааг уялдуулж сургууль бүрд очих олон янзын ачааллыг бууруулах зэрэгт анхаарах шаардлагатай байгааг санал болгосон байна.

ГУРАВ: СУРГАЛТ БОЛОН ҮЗҮҮЛЭХ ХИЧЭЭЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

Зөвлөн туслах ажлын хүрээнд орон нутгийн багш нарт сургалт зохион байгуулав. Сургалтыг тухайн бүсэд томилогдсон багийн гишүүд өөрийн хариуцсан мэргэжлийн чиглэлийн багш нарт зохион байгуулсан бөгөөд нийт 1664 багш хамрагдсан. Эдгээр багш нарын 50.96% нь бага боловсрол байгаа бол суурь, бүрэн дунд боловсролын багш нараас хамгийн олон нь монгол хэлний багш нар 206 (12.37%), хамгийн цөөн нь 10 (0.6%) мэдээллийн технологи, 26 (2.23%) хөгжмийн багш нар байна. Бусад мэргэжлийн хувьд дунджаар 50-60 багш сургалтад хамрагджээ.

Сургалтыг 1 өдрийн хугацаанд дараах агуулга, чиглэлийн хүрээнд хийсэн.

- Сургагч багш нар цөм хөтөлбөрөөс сэдэв сонгон үзүүлэх хичээл зааж, заасан хичээлийн онол, арга зүйн санааг хэлэлцэх
- Бага, суурь, БДБ-ын хөтөлбөрийг чанар, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар онол, арга зүйн зөвлөмж өгөх, багш нар харилцан туршлагаа хуваалцах
 - БДБ-ын сургалтын хөтөлбөрт шинээр нэмэгдсэн болон хүндэвтэр агуулгыг заах арга зүй
 - Үнэлгээний арга зүй, даалгавар боловсруулах арга, аргачлал
 - Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэглэгдэхүүн боловсруулах аргачлал, шинэлэг санаа гэсэн агуулгын хүрээнд судлагдахууны онцлог, багш нарын хэрэгцээнд тулгуурлан сургалтыг зохион байгуулсан байна.

Судлагдахууны чиглэлээр сургалтад хамрагдсан багш нарын тоог хүснэгтэд үзүүлбэл:

№	Судлагдахуун	Сургалтад хамрагдсан багшийн тоо
1	Бага боловсрол	848
2	МХУЗ	206
3	ТНУ	73
4	Дүрслэх урлаг, дизайн технологи	75
5	Биеийн тамир	38
6	Гадаад хэл	75
7	Физик	57
8	Математик	118
9	Хими	31
10	Биологи	41
11	Газарзүй	66
12	Мэдээллийн технологи	10
13	Хөгжим	26
Нийт		1664

Сургалтын онцлог

Энэхүү сургалтыг дээрх ерөнхий агуулга, чиглэлийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд сургагч багш үзүүлэх хичээл заасан нь онцлог байв. Үзүүлэх хичээлийн сэдвийг сонгохдоо зарим багууд аль болох хөтөлбөрт шинээр тусгагдсан, хүндэвтэр, сорил туршилттай сэдвүүдийг сонгосон бол зарим баг тухайн орон нутгийн мэргэжлийн багш нарын хэрэгцээнд үндэслэсэн байна. Мөн зарим багийн хувьд хичээл ажиглаж, хэлэлцүүлэг хийх явцад ажиглагдсан сайжруулах зүйлд үндэслэсэн байхад зарим нь тухайн мэргэжлийн хичээлийн агуулгыг Тогтвортой хөгжлийн агуулга, арга зүйтэй хэрхэн интеграцчилах талаар үзүүлэх хичээл заажээ. Тухайлбал:

- Бага боловсролын судлагдахууны хувьд 5-р ангийн Хүн ба байгаль хичээлийн “Одот тэнгэр” дэд хам сэдвийн 3-р суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх 3 цагийн хичээлийн эхний 2 цагийн хичээлийг “Сар бидэнд яагаад олон хэлбэртэй харагддаг

вэ” сэдвээр заасан. Дээрх сэдвийг сонгох болсон нь нийслэлийн зөвлөн туслах үйл ажиллагааны үед 3 сургуулийн хичээлд ажиглалт, 8 сургуулийн нэгж хичээлийн төлөвлөлтийг шинжлэн үзэхэд багш тухайн хичээлийн агуулгаа хүндрүүлэх, хэрэглэгдэхүүний сонголт, боловсруулалт, заах арга зүй, үнэлгээ, хэрэглэгдэхүүн, сургалтын орчин бүрдүүлэхэд нэлээд асуудлууд үүсч байгаа нь ажиглагдаж байсан. Мөн 2017 оны үндсэн сургалтад тус хичээлийн хэрэглэгдэхүүний нэг санааг нэвтрүүлсэн боловч багш тухайн хэрэглэгдэхүүнийг хийхдээ хэмжээ алдах, харьцаа алдах тохиолдлууд элбэг байсан тул өөр нэгэн хялбар хэрэглэгдэхүүнийг бэлтгэж багш нарт хүртээл болгох хэрэгцээ үүссэн гэж тайландаа тусгасан байна.

- Математикийн хичээлийн хувьд Хавтгайн координатын системд шулууныг вектор хэлбэрээр илэрхийлэх сэдвийг “Jigsaw” аргаар зохион байгуулсан. Энэ нь шинэ мэдлэг бүтээлгэх үр дүнтэй арга бөгөөд багийн гишүүн бүр чухал үүрэг гүйцэтгэдэг тул оролцоог дэмжиж, бусдыг ойлгох чадварыг хөгжүүлдэг. Мөн сурагч бүр нийтлэг зорилгын төлөө үр дүнтэй багаар хамтран ажиллах ба сурагчдын манлайллыг бий болгож, бие биенээ үнэлэх, харилцан дэмжиж ажиллах нөхцөлийг бий болгоно. Эдгээр давуу талыг багш нар олж харсан бөгөөд шууд болон хувиргаж хэрэглэх зорилгоор ашиглах боломжтой.
- ТНУ-ны хичээлийн хувьд Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдлийн харилцан хамаарал” сэдвээр хичээл заасан бөгөөд ахлах ангид үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтийг авч үзэхдээ бид түүнд нөлөөлж буй хүчин зүйл тухайлан ажил эрхлэлттэй тэр болгон холболгүй тус тусад нь судалдаг. Харин энэхүү үзүүлэх хичээлийн хүрээнд улс орны эдийн засгийн хөгжлийг хэмждэг үндэсний үзүүлэлт болон ажил эрхлэлтийн талаар зэрэгцүүлэн судалснаар эдгээр ойлголтын уялдаа холбоо, хамаарлыг тогтоох боломжтой юм. Ингэснээр сурагчид эдийн засгийн үзэгдэл, үйл явдлыг цогцоор нь харилцан хамааралд нь танин мэдэх улмаар тогтвортой хөгжлийн тогтолцоот сэтгэлгээг хөгжүүлэх цогц чадамжтай болоход хувь нэмэрүүлж чадна гэж үзэж байна.
- Монгол хэлний хичээлийн тухайд багш нарын хичээлийг ажиглах явцад хичээлийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, үнэлгээ өөр хоорондоо уялдаа холбоогүйгээр төлөвлөгдөж байгаа нь харагдлаа. Мөн хичээлийн зохион байгуулалт, хэрэглэгдэхүүн хэлбэр төдий байгаа нь цөм хөтөлбөрийн мөн чанараа бүрэн сайн ойлгоогүй байна уу гэсэн дүгнэлтэд хүргэсэн. Тиймээс “Уран сайхны эх ба эсээг харьцуулан дүгнэлт гаргах” сэдвээр үзүүлэх хичээл зааж ээлжит хичээлийн зорилгыг оновчтой дэвшүүлж бодит үйл ажиллагаа болгох, зорилтыг үнэлгээтэй хэрхэн яаж холбож болох, үнэлгээний шалгуурыг хэрхэн боловсруулах талаар арга зүйн санааг харуулахыг зорьсон.
- Биологийн судлагдахуун хувьд 10-р ангийн Диффузи гэсэн сэдвээр үзүүлэх хичээл заажээ. Багш нар суралцахуйн үйл ажиллагааг баримтлан ээлжит хичээлийн төлөвлөлт хийж байгаа боловч тухайн хичээлийн агуулгыг тодорхойлж чадахгүй, өөрөөр хэлбэл ямар мэдлэг, чадварыг эзэмшүүлснээр тухайн хичээлийн зорилгыг хангах, анги болон сэдэв хоорондын залгамж холбоог хэрхэн боловсруулах талаарх ур чадвар хангалтгүй ажиглагдсан тул хамтран арга зүйд суралцах зорилготойгоор энэхүү сэдвийг сонгон багш нар үзүүлэх хичээл заасан байна.
- Газарзүйн судлагдахууны хувьд “Агаарын даралт” сэдвээр үзүүлэх хичээл заасан ба энэхүү сэдвийг 7- 10-р ангийн агуулгын залгамж холбоог ялган гаргах, агаарын даралтын өөрчлөлт нь цаг агаарт хэрхэн нөлөөлөх учир шалтгааныг танин мэдэж, синоптика уншиж, цаг агаарын төлөв байдлыг тодорхойлох, амьдрал ахуйд ашиглах чадварыг төлөвшүүлэх талаар зарим шинэ, санааг өгөх зорилгоор заажээ. Сургалтад хамрагдсан багш нарын тухайд тус хичээлийг суралцахуйн зорилтот нийцсэн зорилго зорилтыг томъёолж, агуулга арга зүй, хэрэглэгдэхүүнээ хэрхэн

оновчтой төлөвлөн хэрэгжүүлж болохыг харуулсан сонирхолтой хичээл боллоо гэж дүгнэсэн байна.

- Физикийн хичээлийн хувьд Хичээлийн хэлэлцүүлгийн үед багш нараас БДБ-ийн агуулгын залгамж холбоо гарган заах тал дээр эргэлзээтэй асуудлууд тулгарч байсанд үндэслэн “Хөшүүргийн тэнцвэрийн нөхцөлийг ашиглах, хэрэглэх” үзүүлэх хичээл орсон. Хэнтий аймгийн БСУГ-ын мэргэжилтэн нийт аймгийн төвийн байгалийн ухааны багш нарт шинжлэх ухаанч эрэл хайлт, дээд түвшний шинжлэх ухаанч эрэлт хайлтын чиглэлээр нэгдсэн мэдээлэл өгөхийг хүссэн тул физикийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж үдээс өмнө нийт байгалийн ухааны багш нарт дараах агуулгаар нэгдсэн мэдээлэл орсон байна. Үүнд:
 - Багшийн хөгжих хэрэгцээ болон БМДИ-ийн үйл ажиллагааны хүрээ
 - Дээд түвшний шинжлэх ухаанч эрэл хайлт, түүнийг хичээлд хэрхэн төлөвлөх арга зүй

Мөн сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу судлагдахууны онцлогт нийцүүлэн дээр дурдсан тодорхой сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Тус сургалтын үр дүнг оролцогчид болон зохион байгуулсан сурагчг багш нар дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

- Бага боловсролын хувьд: Цөм хөтөлбөрийг арга зүйн зөвлөмж, сурах бичиг, багшийн номтой уялдуулж судлах аргатай болж, ээлжит хичээлийн зорилго, зорилтыг зөв томъёолж, төлөвлөх чадвараа нэмэгдүүлсэн. Мөн үнэлгээний даалгавар боловсруулахдаа асуултыг оновчтой зохиох, даалгаврын зорилгыг зөв тодорхойлж, даалгаврын тавилыг шинжлэх, хүүхдээс гарах хариултын хувилбарыг урьдчилан тооцоолох, алдаанд шинжилгээ хийж тухайн хүүхдэд арга зүйн ямар дэмжлэг үзүүлэх шаардлагатайгаа тодорхойлох зэргийн талаар ярилцаж, дадлага хийсэн нь үр дүнтэй болсон талаар тэмдэглэсэн байна.
- Байгалийн ухааны чиглэлийн мэргэжлүүдийн хувьд судлагдахууны онцлогт тохируулан сургалтыг зохион байгуулсан ба энд зарим мэргэжлийн сургалтын онцлогоос дурдвал:
 - Биологийн багш нарт зохион байгуулсан сургалтаар Хөтөлбөр, СЗ, СУ-г судлах, жилийн болон нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийн уялдаа холбоог гаргах, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үндэслэн хичээлийн арга зүй, хэрэглэгдэхүүнийг хэрхэн сонгох талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн нь багш нарын хувьд нэгдсэн ойлголттой болсон гэж үзжээ. Мөн үнэлгээний шалгуур төлөвлөх, шалгууртаа нийцсэн дасгал, даалгавар, ажлын хуудас боловсруулах, ажлын хуудас, дасгал даалгавар нь суралцах чадварын хөгжлийг илрүүлэхүйц, үнэлгээний нотлох баримт, арга хэрэгсэл болохуйц байх, явцын үнэлгээнд гүйцэтгэлийн түвшин, чадварын ахицыг илрүүлэх рубрук боловсруулж хэрэглэх талаар ярилцсан ба энэ чиглэлээр дахин сургалтад хамрагдах хэрэгцээ байгааг илрүүлж, суурь, БДБ-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийг ярилцсан байна.
 - Математикийн багш нарт зохион байгуулсан сургалтын агуулгыг үзүүлэх хичээлтэй уялдуулан төлөвлөсөн нь багшид цогц мэдээлэл, түүндээ нийцсэн багц хэрэглэгдэхүүн болж чадсан. Нэг сэдвийн хүрээнд явуулснаар бусад сэдвүүдэд үлгэрчлэн хэрэглэх нэг аргыг хүргэснээрээ онцлогтой. Багш нар хувьд Geogebra програмыг хэрэглэх хүрээгээ тэлж, ур чадварын түвшингээ ахиулах эхлэл болсон. Үнэлгээний даалгаврыг гүйцэтгэж үзээд, дараа нь шинжлэх, даалгаврын тавилын шинэ санаа дэвшүүлэх дадлага ажил нь сэтгэлгээ шаардсан, бүтээлч хандлагыг өдөөсөн, хэрэгцээнд нь нийцсэн үр дүнтэй үйл ажиллагаа болсон гэж хариуцсан арга зүйч дүгнэсэн байна.

- Мэдээлэл зүйн сургалтын хувьд багш нарт тулгарч байгаа хүндэвтэр сэдвийн хүрээнд программчлал айн агуулгыг хэрхэн хэрэгжүүлэх талаар онолын мэдээлэл өгч, арга зүйн санааг тайлбарлаж, дээрх агуулгын хүрээнд үнэлгээний даалгавар боловсруулсан. Visual Basic программын орчинд ажиллах аргачлал, нэгж, ээлжит хичээлийн үнэлгээний хуудас бэлтгэх нэг загварыг хамтран гаргалаа. Үүнийгээ тус бүрдээ туршин үзэж сайжруулан, туршлага хуваалцахаар болсон байна.

Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжлийн багш нарт зохион байгуулсан сургалтаас хамгийн онцлогтой байгаа мэргэжлээс дурдвал: Үүнд:

- Зураг, дизайн, технологийн мэргэжлийн багш нарт:
 - “Багш бэлтгэх сургуульд заагаагүй сэдвийн хүрээнд юуг ашиглах, ямар багштай хамтран ажиллах,
 - Тухайн сэдвээр өөрсдийн боломжийг ашиглан хичээл заахад анхаарах зүйл, заасны ач холбогдол,
 - Зураг зүйн хичээл хэрэглэхгүйгээр эсгүүрийн загвар гаргах, эсгүүр байгуулахын тулд багш өөрийгөө хэрхэн бэлтгэх, ямар зохион байгуулалт мэддэг байх
 - Металлын шинж чанарыг сурах бичигт хэрхэн тусгасан байдаг, багш юуг анхаарах ёстой, түүнийг мэдсэнээр технологи ажилбар хэрхэн зөв явагдах вэ? зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл, дадлага хийсэн ба эдгээрийн үр дүнд багш шинжлэх ухааны мэдлэгийг хүүхдэд систем дараалалтай өгч, түүнийгээ бүтээлчээр хэрэгжүүлэх чадварт суралцсан гэж дүгнэжээ.
- Биеийн тамирын судлагдахууны хувьд: 10, 11-р ангийн хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, арга зүйн шийдлийг ярилцах, Ээлжит хичээл төлөвлөх арга зүйн дадлага хийх, Биеийн тамирын хичээлийн үнэлгээний шалгуур боловсруулах, боловсруулсан үнэлгээний шалгуурт анализ хийх зэргээр сургалтаа зохион байгуулсан. Оролцогчид цөм хөтөлбөрт байгаа спортын төрлүүдийг заах арга туршлагаа хуваалцан, агуулгын өргөсгөл гүнзгийрлийг хэрхэн тооцох, агуулгын залгамж холбоог тодорхойлох, хичээлийн зорилго, зорилтоо цөм хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн томьёолох зэрэг чадвараа нэмэгдүүлсэн байна.

Үзүүлэх хичээл болон сургалтын үр дүнг үнэлсэн байдлыг нэгтгэн дүгнэвэл:

- Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж (арга зүйн зөвлөмж), сурах бичиг, багшийн номын уялдаа холбоог ойлгосон.
- Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт, хөтөлбөрийг тодорхой, нарийвчилж хийх арга, аргачлалд суралцсан.
- Үнэлгээний шалгуур, даалгавар боловсруулахад анхаарах зүйлийн талаар мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлсэн.
- Суурь, БДБ-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийг ярилцан, зарим хичээлийн хүнд болон шинээр орсон агуулгыг заах арга зүйд суралцсан талаар нийт тайланд тусгагдсан байгаа бөгөөд хамгийн гол үр дүн нь *“багш хичээл заах, ажиглах, хэлэлцэх явцад өөрийн алдаа, дутагдлаа олж харж, буруу ташаа ойлголтоо залруулсан явдал”*, *“ажлын байран дээр зөвлөн туслах нь багш нарт хамгийн бодит дэмжлэг”* боллоо гэж үзсэн байна.

ДӨРӨВ: ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ (ҮР ДҮН, АНХААРАХ ЗҮЙЛ)

Дүгнэлт, үр дүн:

Мониторинг хийх, зөвлөн туслах үйл ажиллагаа нь нэгдсэн төлөвлөгөө, зураглал удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулагдсан. Тус үйл ажиллагаанд аймгийн БСУГ, НБГ, дүүргийн БХ-ийн мэргэжилтнүүд хамтран ажилласан бөгөөд хөдөө орон нутгийн 84, нийслэлийн 47 нийт 131 сургуулийн багш, ажилтнууд хамрагджээ. Сургууль тус бүр дээр бага боловсрол, нийгмийн ухаан, байгалийн ухаан гэсэн 3 судлагдахууны чиглэлээр нийт 690 багшийн хичээлд ажиглалт, хэлэлцүүлэг хийж зөвлөгөө өгсөн байна. Эдгээрийг боловсролын түвшингээр нь авч үзвэл бага боловсролын 241, суурь боловсролын 223, бүрэн дунд боловсролын 226 хичээл байна.

Хичээлийн ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүн, багш нарын санал хүсэлтээс харахад сургалтын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд дараах асуудлууд нөлөөлж байна. Үүнд:

- Сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж (арга зүйн зөвлөмж), сурах бичиг, багшийн номын уялдаа холбоог бүрэн сайн ойлгоогүй, уншиж, судлаагүй байдал
- Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлтийг оновчтой боловсруулж, хэрэгжүүлэхгүй хэлбэр төдий хийж, батлуулж буй байдал
- Хичээлийн зорилго, зорилтыг хэрэгжиж, хэмжигдэхүйц тодорхойлж, үр дүнг үнэлж дүгнэх арга аргачлалаа ойлгоогүй, мэдэхгүй байгаа байдал
- Явцын болон эцсийн үнэлгээг мөн чанараар ойлгож, хэрэгжүүлэх мэдлэг, чадвар хангалтгүй
- Багш нарын хувийн хариуцлага, хандлага
- Сургалтын менежерүүдийн мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн туслах мэдлэг, чадвар харилцан адилгүй
- Сурах бичиг хэвлэгдэн гараагүй, хүрэлцээ, хангамж муу
- Сургалтын хэрэглэгдэхүүн, орчин бүрдэлт дутмаг зэрэг нь багшид тулгамдаж буй гол асуудал болж байна.

Зөвлөн туслах ажилд хамрагдсан сургуулийн багш, удирдлага болон үндэсний хэмжээнд ажилласан багийн гишүүд энэхүү ажлыг, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлсэн, цаг үеэ олсон ажил болж дараах үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн ажлын байранд зөвлөн тусалж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлснээр тус үйл ажиллагаанд хамрагдсан багшийн арга зүйн чадавх нэмэгдсэн.
- Аймаг тус бүрийн мэргэжлийн багш нарт сургалт, үзүүлэх хичээл зохион байгуулснаар тухай мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх онол, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.
- Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнүүд, сургуулийн удирдах ажилтнууд тус ажилд хамтран оролцсоноор (сургалтын менежер) харилцан бие биеэсээ суралцаж, туршлагажсан.
- Багшийн ёс зүй, харилцааны ур чадвар болон бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд үүсч буй асуудал, бэрхшээлийг илрүүлж, багшид онол, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын цаашдын чиглэл тодорхойлсон
- Суурь, БДБ-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийг ярилцан, зарим хичээлийн хүнд болон шинээр орсон агуулгыг заах арга зүйд суралцсан бөгөөд хамгийн гол үр дүн нь “багш хичээл заах,

ажиглах, хэлэлцэх явцад өөрийн алдаа, дутагдлаа олж харж, буруу ташаа ойлголтоо залруулсан явдал” гэж үзсэн байна.

Ажлын байран дээр зөвлөн туслах ажил нь сургууль, багшийн хөгжилд хамгийн бодит дэмжлэг болж байгаа талаар үйл ажиллагаанд оролцогчид цохон тэмдэглэсэн бөгөөд цаашид энэхүү ажлыг үе шаттайгаар, тогтмол зохион байгуулж байх хэрэгцээ байгаа нь харагдлаа. Мөн тус ажлын үр дүн, дүгнэлтээс харахад хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажлыг тасралтгүй чанартай зохион байгуулж байх хэрэгцээ ч харагдаж байна. Тухайлбал: бага боловсролын хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш массыг хамарсан, томоохон сургалт, үйл ажиллагааг төдийлөн хийгээгүй, Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг орон нутаг хариуцан зохион байгуулсан боловч чанар, үр дүн нь харилцан адилгүй байгаа зэрэг нь багш, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөлсөн гэдэг дүгнэлт хийхэд хүргэж байна.

Иймд зөвлөн туслах ажлын үр дүн, тус үйл ажиллагааг зохион байгуулсан багийн дүгнэлт, дээрх үйл ажиллагаанд хамрагдсан сургууль, багш нарын санал, хүсэлт, хэрэгцээнд үндэслэн БМДИ-ийн арга зүйчид болон сургалтын хөтөлбөр, сурах бичиг зохиогчидтой хамтарч судлагдахуун тус бүрээр буюу 15 чиглэлээр зөвлөмж боловсруулан орон нутагт хүргэж ажлыг шуурхай зохион байгууллаа. *Тус зөвлөмжийг хавсралтаас дэлгэрүүлэн үзнэ үү.*

Анхаарах зүйлс:

Төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотой:

- Орон нутагт ажиллах хүний нөөцийн бүрэлдэхүүний хуваарилалтад анхаарах. нэг бүсэд ажиллах бүрэлдэхүүнийг сонгохдоо бага боловсрол, байгалийн ухаан, хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжлийн хүнийг сонгосон боловч бага, суурь, бүрэн дундын түвшинд нэг чиглэлээр мэргэшсэн хүмүүс хуваарилагдсан.
- Судлагдахуун тус бүрээр 2 бүс буюу 4 аймаг, 2 дүүрэгт ажиллах хуваарь, хийсэн боловч 2 судлагдахууны хувьд хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж 1 бүс буюу 2 аймг, 1 дүүрэгт ажилд хамрагдсан. Тиймээс мэргэжлийн арга зүйч хүндэтгэх шалтгаантай үед нөхөж ажиллуулах үндэсний сурагч багшийг бэлтгэсэн байх шаардлага харагдаж байна.
- Гаднаас зочин багш урьж ажиллуулах тохиолдолд хариуцлагын гэрээ байгуулах.

Тайлан боловсруулахтай холбоотой.

- Багийн ахлагч болон багийн гишүүд тайланг нэгдсэн бүтэц, форматын дагуу бүрэн гүйцэд бичиж, хугацаанд нь ирүүлэхэд онцгой анхаарах Үүнд:
 - Тайлангийн бүтцийн дагуу мэдээллийг бүрэн гүйцэт оруулах
 - Тайлан бичихдээ нэрлэж, жагсаахаас илүү тоо баримтаа нэгтгэж, багцлан дүгнэж бичих
 - Зарим тайлангууд бие биенээсээ хуулсан, ижил байгаад анхаарах
 - Хариуцлагатай, сэтгэлтэй хандах
 - Үг, үсэг, найруулгын алдаагүй байх

Боловсролын салбарын байгууллагуудын анхаарах зүйл: (оролцогчдын санал, хүсэлтэд үндэслэв.)

Сургуулийн түвшинд:

- Багш бүр бага, суурь болон бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг дахин сайтар судалж, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг сайжруулах,
- Сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг төсөвт тусгах

- Сургалтын менежерүүд багштай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн дэмжлэг тогтмол үзүүлж байх
- Багш нар хариуцлагатай, бүтээлч байх

Орон нутгийн түвшинд:

- Орон нутагтаа зөвлөн туслах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах
- Орон нутгийн сургагч багш болон лаборатори сургуулийн үүрэг оролцоог сайжруулах
- Байгалийн ухааны судлагдахууны хувьд аймгийн багш нар хамтран онолын мэдлэгээ ахиулах, туршилтуудыг хамтран хийж хэвших
- Орон нутагт зохион байгуулагдаж буй сургалт, үйл ажиллагааг чанаржуулах

БМДИ, БХ:

- Сургалтын менежерүүдэд үндсэн сургалтаар судлагдахууны хөтөлбөрийг судлах цаг оруулах. Ингэснээрээ багшдаа зөвлөх боломж бүрдэнэ.
- Орон нутгийн БСУГ-ын мэргэжилтэн, сургалтын менежерүүдийг хичээл ажиглах, хэлэлцүүлэг хийх замаар зөвлөн туслах ажлын арга зүйд суралцуулах
- БСУГ-ын мэргэжилтэн, сургалтын менежерүүдийг нэгдсэн сургалтад хамруулах, чадваржуулах
- Хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлд үндэслэн bagsh.itpd.mn сайтад зөвлөмжөө үргэлжлүүлэн байршуулах,
- Зөвлөн туслах ажлыг 3 судлагдахуунаар явахад бусад судлагдахууны хувьд ялгаатай байдал, ойлголтын зөрүү үүсэх тал байгаа тул бүх мэргэжлээр нэг зэрэг тодорхой графикайн дагуу аймаг бүрд хүрч ижил түвшний нэгдсэн ойлголт өгөх
- Үндсэн сургалтын агуулгад хичээл төлөвлөх болон сурах бичгийг хэрэгжүүлэх арга аргачлалыг олгох цагийг нэмэгдүүлэх
- Математикийн багш нарын хувьд судлагдахууны онцлогоос шалтгаалж, шинжлэх ухааны мэдлэг, чадварыг хэт дээдлэх, үүнд чиглэсэн олимпиад, уралдаан тэмцээнд түлхүү анхаарах хандлага байсаар байна. Иймд математикийн багшийн үндсэн зорилго, математикийн хичээлийн мөн чанар, түүгээр хүүхдийн олж авах үндсэн мэдлэг, чадвар, хандлагыг ухамсарлуулан ойлгуулахад чиглэсэн ажлуудыг шат дараатай, залгамж холбоотойгоор явуулах зайлшгүй шаардлага тулгараад байна. Үүнийг БСШУСЯ, БМДИ, БХ, БҮТ, ММОХ(Монголын Математикийн Олимпиадын Хороо) зэрэг байгууллагууд хамтран нээлттэй хэлэлцүүлэг хийж, харилцан ойлголцолд хүрч, цаашдын үйл ажиллагаагаа уялдуулан төлөвлөх замаар шийдвэрлэх
- Олон үйл ажиллагаанд зэрэг төвлөрөлгүй, хичээлд сууж, зөвлөгөө өгөх зөвлөн туслах үйл ажиллагааг графикт тусган хэрэгжүүлэх
- Үнэлгээний олон арга хэлбэр, техникүүдийг нэгж болон ээлжит хичээлд тусгах, хэрэгжүүлэх, судлагдахууны онцлогт тохируулан хэрэглэх талаар тусгайлсан сургалт, хэлэлцүүлэг, онол практикийн бага хурал зэргийг зохион байгуулах

БСШУСЯ:

- Цөм хөтөлбөр, бага суурь БДБ-ын суралцахуйн удирдамжийг ном болгон хэвлэж багш бүрд хүргэх
- Орон нутагт орос хэл сонирхож буй сурагчдын тоо цөөн, анги бүлэг бүрдэхгүйн улмаас "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" хэрэгжих боломжгүй байна. Иймээс сургалтын төлөвлөгөөнд орос хэл болон англи хэлний судлагдахууныг заавал судлах хичээлээр тусад нь салгаж өгөх, орос хэлний хичээлийн цагийг нэмэгдүүлэн, тухайн хэлийг сонирхож буй сурагчид 7-12 дугаар ангиудад орос хэлийг тасралтгүй судлан ОХУ-ын их дээд сургуулиудад хэлний

бэлтгэлгүйгээр тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжийг бий болгоход шийдвэр гаргах түвшний байгууллагууд анхаарах

- Биеийн тамирын судлагдахууны хувьд БДБ-ын багшийн номтой болгох
- Газарзүйн хичээлийн цагийг хассантай холбоотой мэргэжлийн бус хүн зааснаар сурагч авах ёстой үйлчилгээгээ бүрэн авахгүй байх, багшийн ажлын байрны эрх зөрчигдөх, хөтөлбөрийн агуулгыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд энэ байдал нь нөлөөлж байгааг эргэж харах
- Дизайн, Зурагзүй, Технологи, Дүрслэх урлаг гэсэн мэргэжлийн дөрвөн үндсэн чиглэлийг бүх ангид нэгтгэн “Дизайн, технологи” “Дүрслэх урлаг, технологи” гэсэн нэг хичээл болгон бага, суурь бүрэн дундын бүх ангид орох нь оновчгүй байна. Ингэснээрээ Монгол Улсын ирээдүйн инженер, зохион бүтээгч дизайнер, технологийн инженерийн суурь хичээлүүдийг нэгтгэн оруулснаар сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг алдагдуулж байна.
- Булган аймгийн ЕБС-ын хөгжмийн багш нар мэргэжлийн сургууль төгсөөгүй, боловсон хүчний хувьд дутагдалтай байна. Одоо ажиллаж байгаа багш нарыг хөрвөх болон эчнээ сургалтад хамруулан баримт бичгийг бүрдүүлэх зайлшгүй хэрэгтэй байна.
- Өмнөговь аймагт мэдээллийн технологийн мэргэжлийн багш дутмаг, зарим сургуульд мэргэжлийн бус хүн тус хичээлийг зааж байна.